



НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/52

Улаанбаатар хот

Дүрэм, бүтэц, зохион байгуулалт
орон тооны дээд хязгаарыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвийн дүрмийг нэгдүгээр, бүтэц, зохион байгуулалтыг хоёрдугаар, орон тооны дээд хязгаарыг гуравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Дүрэм, бүтцийг үйл ажиллагаандаа мөрдөж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төв (М.Мөнгөнцэцэг)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвийн дүрэм, бүтэц, үйл ажиллагааны чиглэлийг баталсан Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2016 оны А/26 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, нэгдсэн удирдлагын хэлтэс (У.Бат-Очир)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Н.НАРАНБААТАР

1526010195

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2026 оны
23 дугаар сарын 17-ны өдрийн 4 дугаартай
тушаалын нэгдүгээр хавсралт

НИЙСЛЭЛИЙН ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ТӨВИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа Нийслэлийн зоонозын өвчин судлалын төв (цаашид ЗӨСТөв гэх) нь нийслэлийн хэмжээнд байгалийн голомтот, зоонозын халдварт өвчний чиглэлээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сургалт, судалгаа шинжилгээтэй хослуулан үзүүлэх, эрүүл мэндийн бусад байгууллагыг мэргэжил, арга зүй, зөвлөгөө, зааварчилгааг хангаж ажиллах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах чиг үүрэг бүхий эрүүл мэндийн тусгай мэргэжлийн төв байгууллага мөн.

1.2. Төв нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Нийгмийн Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Төсвийн тухай хууль, Иргэний хууль, Төрийн албан хаагчийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, Засгийн газар, Эрүүл мэндийн яам, Нийслэл болон Дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурал, Нийслэл болон Дүүргийн Засаг дарга, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн дарга нарын шийдвэрийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.

1.3. Төв нь Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа төрийн өмчит хуулийн этгээд байна.

1.4. Төв нь Нийслэлийн Эрүүл мэндийн гарын дарга болон Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн өмнө үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг хариуцаж тайлагнана.

1.5. Төвийн оноосон нэр нь “Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төв” байх ба товчилсон нэр нь “НЗӨСТ” гэж үйл ажиллагаандаа хэрэглэнэ.

1.6. Төвийн албан ёсны хаяг нь Монгол Улс, Улаанбаатар хот, Багануур дүүрэг 5-р хороо Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвийн өөрийн байр, Холбоо барих утас: 70210316, цахим хаяг www.bgots.ub.gov.mn, цахим шуудангийн хаяг nzustnews@gmail.com байна.

1.7. Төв нь холбогдох хууль тогтоомжийн дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, туг, санхүүгийн харилцах данстай байна.

1.8. Энэхүү дүрэм нь төвийн эрх зүйн байдал, үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг тодорхойлж, удирдлага, зохион байгуулалт, бүтцийг тогтоон, түүнтэй холбогдох нийтлэг харилцааг зохицуулах баримт бичиг мөн.

Хоёр. Төвийн үндсэн зорилго, чиг үүрэг

2.1. Төвийн алсын хараа: Зоонозын халдвар, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг шинжлэх ухааны нотолгоонд суурилан эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээний цогц үйл ажиллагааг зохион байгуулахад оршино.

2.2.Төвийн эрхэм зорилго: Байгалийн голомтот зоонозын халдварт өвчний эрт сэрэмжлүүлэх хариу арга хэмжээний ажлын хүрээнд салбар дундын хамтын ажиллагааг чанаржуулах био аюулгүй ажиллах нөхцөлийг үе шаттай бүрдүүлэх

2.3.Төвийн чиг үүрэг: Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламжийн тухай хууль, Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хүн амд сургалт сурталчилгаа, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх.

Гурав.Төвийн удирдлага, зохион байгуулалт,эрх үүрэг

3.1.Төвийн дүрэм, зохион байгуулалтын бүтэц, гүйцэтгэлийн төлөвлөгөө, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга батална. Календарчилсан төлөвлөгөөг ЗӨСҮТ-ийн захирал, НЭМГ-ын дарга батална.

3.2.Төвийн удирдах дээд албан тушаалтан нь төвийн дарга байх бөгөөд төвийн даргыг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, томилж чөлөөлнө.

3.3.Төвийн удирдлагын багийн бүрэлдэхүүнд Дарга, Ерөнхий нягтлан бодогч, Хүний нөөцийн ажилтан, Тандалт, Лабораторийн тасгийн эрхлэгч нараас бүрдэнэ.

3.4.Төв нь нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулах тандалтын тасаг, лабораторийн тасаг, удирдлага үйлчилгээний тасагтай байна.

3.5.Төв нь дэргэдээ орон тооны бус даргын зөвлөл, халдвар хамгааллын дэглэмийн комисс, эрүүл мэндийн ажилтны ёс зүйн баг, чанарын баг, эрсдэлийн баг, дотоод хяналт шалгалтын баг, хөдөлмөр аюулгүй байдлыг хариуцсан ажилтан, эцэг эхийн зөвлөл болон шаардлагатай тохиолдол бусад зөвлөлийг шинэчлэн баталж ажиллуулна.

3.6.Эрүүл мэндийн ажилтны ёс зүйн салбар хороо нь ёс зүйтэй холбогдон гарсан тушаал, шийдвэр, дүрэм журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.

3.7.Зөвлөх эмч болон НЗӨСТ-ийн бүтэц орон тоонд нь батлагдаагүй зайлшгүй шаардлагатай мэргэжилтнүүдтэй хөдөлмөрийн тухай хуулийн дагуу гэрээгээр ажиллуулна.

3.2.Төвийн дарга дараах эрх үүрэг:

3.2.1.НЗӨСТ-ийн өдөр тутмын үйл ажиллагаа удирдах.

3.2.2.Байгууллагын хэмжээнд сахилга, дэг журам, төрийн албан хаагчийн ёс зүйн хэмжээг сахиулан, ажилтнуудад хяналт тавьж ажиллах.

3.2.3.Хуулиар тогтоосон эрх, хэмжээний хүрээнд албан хаагч, ажилтнуудыг томилж чөлөөлөх.

3.2.4.Хууль тогтоомжийн дагуу Хөдөлмөрийн дотоод журам батлах, ажилтнуудын цалин, урамшууллыг тогтоож, эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал, заавар, дүрэм, журам гаргаж мөрдүүлэх.

3.2.5.Тасгуудын төлөвлөгөөг баталж, хяналт тавьж ажиллах.

3.2.6.Байгууллагын зохион байгуулалтын бүтцийг оновчтой тогтоож, ажлын байрны чиг үүргийн давхардал, зөрчлийг арилгах, уялдаа холбоог сайжруулах, албан хаагчдыг мэргэшүүлэх, чадваржуулах, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлын зохион байгуулах.

Дөрөв.НЗӨСТөвийн үүрэг

4.1.НЗӨСТөв нь Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяанд ЗӨСҮТөвийн мэргэжил арга зүйн удирдлага дор ажиллана.

4.2.Төв нь байгалийн голомтот, зоонозын халдварт өвчний талаарх Олон улсын болон Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, эрх зүйн баримт бичиг, өөрийн үйл ажиллагааны онцлогийг тусгасан зоонозын өвчин судлалын төвийн бүтэц, үйл ажиллагааны стандарт, зоонозын халдвар хамгаалал, био-аюулгүй ажиллагааны дэглэмийн заавар, зоонозын өвчний хүн амын дундах тандалт судалгааны заавар, журмыг баримтлах.

4.3.Төв нь эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын хүрээнд алсын хараа, хэтийн зорилго, зорилтыг тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө, байгууллагын дотоод журам, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах талаар төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэн ажиллах.

4.4.“Нэг эрүүл мэнд” үзэл баримтлалын хүрээнд зоонозын өвчлөлийн чиглэлээр салбар хоорондын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох

4.5.Төв нь байгалийн голомтот, зоонозын халдварт өвчний үйл ажиллагааны чиглэлээр бодлогын баримт бичиг боловсруулахад санал өгөх.

4.6.Төв нь өөрийн үйл ажиллагаандаа мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэн, үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр удирдах дээд байгууллага болон иргэдийг тогтмол хангах

4.7.Төв нь нийслэлд байгалийн голомтот, зоонозын халдварт өвчний дэгдэлтэд хариу арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах.

4.8.Нийслэлд байгалийн голомтот, зоонозын халдварт өвчний эрсдэлт хүчин зүйлсийг тандах, судлах, хянах, сэргийлэх, шинжлэх.

4.9.Төв нь эмч мэргэжилтэн ажилтнуудыг байгалийн голомтот, зоонозын халдварт өвчний чиглэлээр төгсөлтийн дараах мэргэшүүлэх, албан ба албан бус сургалт, гадаад дотоодын магистрантур, докторантурын сургалтад хамруулах.

4.10.Байгалийн голомтот зоонозын халдварт өвчний микробиологийн чиглэлээр лабораторийн онош зүйн тусламж үйлчилгээ үзүүлж, ЗӨСҮТөвд үр дүнг баталгаажуулах.

4.11.Байгалийн голомтот, зоонозын халдварт өвчний вакцин, ийлдэс, оношлуур, био-бэлдмэл, тэжээлт орчин, будаг урвалжийг захиалах, зарцуулалтыг тооцох.

4.12.Төв нь үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэлийн үр дүнг НЭМГ, ЗӨСҮТөвд тайлагнах.

4.13.Төв нь үйл ажиллагаа, хүний нөөц, санхүү төсвийн нээлттэй, ил тод зарчмыг баримтлан санхүүгийн нөөцийн төлөвлөлтийн бодит болон нотолгоонд тулгуурласан байдлыг хангаж, “Шилэн дансны тухай” хуулийг мөрдөн ажиллах.

4.14.Төв нь ажиллагсдын нийгмийн баталгааг хангах, ажлын байрны нөхцөлийг сайжруулах талаар төлөвлөгөө гарган ажиллах.

4.15.Төв нь ажиллагсдын мэдлэг ур чадварыг байнга дээшлүүлж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, сахилга хариуцлагын хэм хэмжээг мөрдүүлж ажиллах.

4.16.Хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

Тав.Төвийн эрх

5.1.Батлагдсан төсөв санхүүжилтийн хүрээнд орон тоог батлах, эрүүл мэндийн ажилтны цалин, хэвийн бус нөхцөлийн нэмэгдэл, ур чадварын болон бусад нэмэгдлийг хууль тогтоомжийн дагуу тогтоож олгох, захиран зарцуулах.

5.2.Ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэн тусламж, үйлчилгээг сайжруулах, байгууллага болон хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр харилцан туршлага солилцох.

5.3.Байгалийн голомтот, зоонозын халдварт өвчний чиглэлээр судалгаа шинжилгээг хөгжүүлэн, эрдэм шинжилгээний хурал, сургалт, семинар зохион байгуулах.

5.4.Төв нь тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй стандартын дагуу үзүүлэхэд эм, эмнэлгийн хэрэгсэл, хөрөнгө оруулалтын асуудлаар удирдах дээд байгууллага нотолгоонд суурилсан санал боловсруулан тавьж шийдвэрлүүлэх.

5.5.Төв нь хууль тогтоомж, төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийн дагуу тусламж үйлчилгээг төлбөртэй үзүүлэх.

5.6.Гамшгаас хамгаалах болон гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах, холбогдог хариу арга хэмжээг хэрэгжүүлэх.

5.7.Хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх.

Зургаа. Төвийн тасгуудын ерөнхий чиг үүрэг

6.1.Удирдлага үйлчилгээний тасаг:

6.1.1.Удирдлага үйлчилгээний тасгийн дарга нь өдөр тутмын үйл ажиллагааг төвийн даргын удирдлага дор зохион байгуулах.

6.1.2.Байгууллагын дотоод журам, стратеги төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөө, календарчилсан төлөвлөгөөг байгууллагын хэмжээнд боловсруулан хяналт тавих, тайлагнах, байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах.

6.1.3.Салбарын хүний нөөцийн хөгжлийн бодлого, стратеги, хөтөлбөр, хууль, журам, тушаал, бусад шийдвэрийн хэрэгжилтийг байгууллагын түвшинд зохион байгуулах, байгууллагын хүний нөөцийн хэрэгцээг тооцож, төлөвлөх, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулах.

6.1.4.Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах болон цалин урамшууллын хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

6.1.5.Байгууллагын хөгжлийн төлөвлөгөө, бодлогын болон эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтэд үнэлгээ хийх.

6.1.6.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, ажлын байрны эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх.

6.1.7.Төвийн архив, албан хэрэг хөтлөлтийг холбогдох хууль тогтоомж, стандарт, заавар журмын хүрээнд хөтлөх.

6.1.8.Удирдлагын багийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлыг төлөвлөх, хэрэгжилтийг хангуулах, үр дүнг танилцуулах.

6.1.9.Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлэх.

6.1.10.Эрдэм шинжилгээ, судалгаа болон гадаад хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөрийг салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлттэй нийцүүлэн боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг төвийн даргад тухай бүр танилцуулан шийдвэрлүүлэх.

6.1.11.Төвийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах ажлыг зохион байгуулах, цаг үеийн мэдээ, мэдээллийг түгээх, байгууллагын албан ёсны цахим хуудасны мэдээллийн санг баяжуулах.

6.1.12.Байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг тасралтгүй сургах, чадавхжуулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх.

6.2.Тандалтын тасаг:

6.2.1.Нийслэлийн хэмжээнд зоонозын хүний өвчлөл бүртгэгдсэн тохиолдолд тухайн дүүргийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран хариу арга хэмжээг оновчтой зохион байгуулах.

6.2.2.Эрүүл мэндийн байгууллага болон зорилтот бүлгийн хүн амын дунд сургалт сурталчилгааг зохион байгуулан ажиллах.

6.2.3.Байгалийн голомтот, зоонозын халдварын голомттой Төв аймгийн бүс нутагт тандалт судалгаа, шинжилгээ болон зорилтот бүлгийн хүн амын дунд мэдлэг, дадал, эрсдэлийг үнэлэх тандалт судалгаа, шинжилгээг зохион байгуулан ажиллах.

6.2.4.Халдвар хамгааллын дэглэмийн зааврыг мөрдөн ажиллах, нийт ажилтнуудын дунд дэглэмийн баримтлуулан, байгууллагын халдвар хамгааллын асуудлыг зохицуулан ажиллах.

6.2.5.Голомтын эцсийн халдваргүйжүүлэлтэнд хяналт тавьж ажиллах.

6.2.6.Байгууллагын өдөр тутмын цэвэрлэгээ халдваргүйжүүлэлтэнд хяналт тавьж ажиллах.

6.3. Лабораторийн тасаг:

6.3.1.Тус тасаг нь 1 эрхлэгчтэй байх ба лабораторийн үйл ажиллагааг

6.3.2.Лабораторийн мэдээллийн санг бүрдүүлэх.

6.3.3.Олон улсын эрүүл мэндийн дүрэм, зоонозын халдварт өвчний талаар, Олон улсын болон Монгол улсын хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдийг мөрдөх, ЭМС-ын тушаалаар батлагдсан халдвар хамгааллын дэглэм болон био-аюулгүй ажиллагааны заавар журмыг баримтлах.

6.3.4.Стандартын шаардлагад нийцсэн микробилогийн тэжээлт орчин, будаг урвалж уусмал, оношилгооны нян залгиурыг ашиглан шинжилгээ судалгааг хийж гүйцэтгэх.

6.3.5.Хээрийн тандалт шинжилгээг зохион байгуулан ажиллах.


6.3.6.Лабораторит суурилсан тандалт шинжилгээг ахлан, заавар журмын дагуу хийж гүйцэтгэнэ.



Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2026 оны
дугаар сарын 17-ны өдрийн А/с дугаартай
тушаалын хоёрдугаар хавсралт

9025101255 CTC6091 9077456

НИЙСЛЭЛИЙН ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ТӨВИЙН БҮТЭЦ



Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2026 оны
03 дугаар сарын 17-ны өдрийн 4 дугаартай
тушаалын гуравдугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ТӨВИЙН ОРОН ТООНЫ
ДЭЭД ХЯЗГААР

№	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Орон тооны дээд хязгаар
1	Нийслэлийн Зоонозын төвийн дарга	1
2	Нийслэлийн Зоонозын төвийн тоо	21
Нийт		22